



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/210

Ховд

Эзэмшил газрын хэмжээ, талбай өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, 2016 оны 55 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Жаргалант сумын Магсаржав багийн 3 дугаар гудамжны 21 тоотод байрлах Цэрэндондогийн Сүхбаатар /ПЮ57120476/-ийн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1000 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 796 метр квадрат, хаягийг Баянгол 4 дүгээр гудамжны 407 а тоот болгон 19 жилийн хугацаагаар өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшил газрын хэмжээ талбай өөрчлөгдөж байгаа иргэнд газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/210 Ch
02 00936